



“МИАТ” ТӨХК-Д

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОХИРУУЛАГЧ АГЕНТЛАГ

**ШУДАРГА ӨРСӨЛДӨӨН,  
ХЭРЭГЛЭГЧИЙН ТӨЛӨӨ ГАЗАР**

Засгийн газрын XII байр, Барилгачдын талбай 13,  
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15170  
Утас: 26 26 53, Факс: (976-11) 32 00 41,  
Цахим шуудан: contact@afccp.gov.mn,  
Цахим хуудас: www.afccp.gov.mn

2024 · 08 · 29 № 01 / 1498  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

**Тендерийн баримт бичиг  
хянасан тухай**

Танай компаниас зарласан “Агаарын хөлгийн иж бүрэн даатгал” МИАТ/20240103122 дугаартай тендер шалгаруулалтын баримт бичигт “Ард даатгал” ХК-аас гомдол ирүүлснийг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 58 дугаар зүйлд заасны дагуу хяналаа.

Тендер шалгаруулалтын баримт бичгийн ТШЗ 19.1-т “Үйлчилгээ үзүүлэх хүний нөөц: “Шаардана”,...а) Англи хэлний ахисан түвшний мэдлэгтэй байх /IELTS-ийн 6 ба түүнээс дээш, TOEFL iBT - 60 ба түүнээс дээш оноо авсан байх эсвэл Англи хэлээр гадаад улсад сургууль төгсөн бакалавр эсвэл магистрийн диплом авсан байх, дипломын хуулбар, сертификатыг ТББ-д хавсарган ирүүлэх/” гэж заасан байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д “Захиалагч гэрээний үүрэг гүйцэтгэхэд сонирхогч этгээд болон оролцогчид тавигдах зайлшгүй шаардлагад үндэслэсэн санхүүгийн болон техникийн чадавх, туршлагын талаар хангавал зохих доод шаардлага, шалгуур үзүүлэлтийг тендер шалгаруулалтын баримт бичигт заана.” гэж, 15.4-т “Энэ хуульд өөрөөр заагаагүй бол захиалагч гэрээний үргийн гүйцэтгэлд үл хамаарах шаардлагыг тендер шалгаруулалтын баримт бичигт заахыг хориглоно.” гэж, 17 дугаар зүйлийн 17.2-т “Техникийн чадавх, туршлагын талаарх мэдээллийг дараах баримт бичгээр нотолж болно:” гэж, 17.2.3-т “гэрээний үргийн гүйцэтгэлийг хариуцах ажилтны нэр, боловсрол, мэргэжлийн ур чадварын мэдээлэл;” гэж тус тус заасан байна.

Захиалагч тендерийн баримт бичгийн ТШЗ 19.1-д “...а) Англи хэлний ахисан түвшний мэдлэгтэй байх /IELTS-ийн 6 ба түүнээс дээш, TOEFL iBT - 60 ба түүнээс дээш оноо авсан байх эсвэл Англи хэлээр гадаад улсад сургууль төгсөн бакалавр эсвэл магистрийн диплом авсан байх, дипломын хуулбар, сертификатыг ТББ-д хавсарган ирүүлэх/” гэж заасан нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.4-т заасныг тус тус зөрчсөн гэж үзэх үндэслэлтэй байна.

Иймд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.5.2 дахь заалтыг үндэслэн тендерийн баримт бичгийн ТШЗ 19.1-д холбогдох өөрчлөлт оруулан, хэрхэн

0003334

шийдвэрлэсэн талаар эргэж мэдэгдсэний үндсэн дээр тендер шалгаруулалтыг үргэлжлүүлэн явуулахыг даалгаж байна.

